

ТАНИЛЦУУЛГА

*Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай*

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлж боловсрууллаа.

Өнөөгийн хучин төгөлдөр мөрдөгдөж буй ашигт малтмалын тухай хуулиар зөвхөн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг улсын төсөвт төлөхөөр зохицуулагдаж байна.

Энэ нь тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй бичил уурхайгаар ашигт малтмал олборлож буй хоршоо, нөхөрлөл, тэдгээрээс ашигт малтмал худалдан авч экспортолсон, худалдсан этгээд болон ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлөхгүй, холбогдох байгууллагуудад тайлан, мэдээ өгөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Үүнээс улбаатайгаар Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "Татвар ногдох зүйлд орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, тодорхой эрх, газар, түүний хэвлий, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц, агаар, хөрс, усны бохирдол хамаарна" гэснийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэж байна.

Үндэсний статистикийн газраас авсан мэдээллээр 2012-2016 онд нийт 381 сая ам долларын 1.6 сая тонн жонш экспортод гарсан байна. Тухайн жилүүдэд 34.6 тэрбум төгрөг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хэлбэрээр улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх байснаас 11.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Гаалийн ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газрын мэдээллээр 2017 онд нийт 319.3 мянган тонн жонш экспортод гарснаас 172.3 мянган тонн нь тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө, тайлангийн аль нэгийг ирүүлээгүй аж ахуйн нэгжээс экспортлогдсон бол 19.1 мянган тонн нь тусгай зөвшөөрөлгүй аж ахуйн нэгжээс экспортод гарсан байна.

Мөн Улсын Их Хурлын 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр баталсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд заасан "Монголбанк, арилжааны банканд худалдсан биет болон биет бус алтны нөөц ашигласны төлбөр борлуулалтын үнэлгээний 2,5 хувьтай тэнцүү" гэсэн заалт 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөр дуусгавар болж байна.

Үүнтэй холбоотойгоор алт олборлогч болон алт худалдан авагч хуулийн этгээдүүд алтыг хууль бусаар хил давуулан худалдах, олборлосон алтаа нуух, хадгалах, татвараас зайлсхийх зорилгоор арилжааны банканд тодорхой бус хугацаагаар барьцаалах зэрэг шударга бус далд үйл ажиллагаа гарах хандлага ажиглагдах нөхцөл бий болохоор байна.

Монголбанкнаас авсан мэдээллээр Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд заасан “Монголбанк, арилжааны банканд худалдсан биет болон биет бус алтны нөөц ашигласны төлбөр борлуулалтын үнэлгээний 2,5 хувьтай тэнцүү” гэх заалт хэрэгжсэн 5 жилийн хугацаанд банканд тушаасан алтны хэмжээ 2014 онд 12.7 тонн, 2015 онд 15.1 тонн, 2016 онд 18.3 тонн, 2017 онд 20 тонн болж өсөн гадаад валютын нөөцийг нэмэгдүүлсэн нь хуулийн уг заалтыг дахин үргэлжлүүлэн 5 жилийн хугацаанд мөрдөх нь зүйтэй байгааг харуулж байна.

Мөн аливаа этгээдийн тушаасан алтны төлбөрөөс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг суутган тооцох, түүнийг төсөвт төлөх, тайлагнах үүргийг Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд хүлээлгэх шаардлагатай байна.

Дээр дурьдсан асуудлуудыг шийдвэрлэх талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Сангийн яаманд салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүд, мэргэжлийн холбоод болон бусад холбогдох байгууллагуудаас удаа дараа хүсэлт гаргасан болно.

Тухайлбал, Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3.3-д орсон “Монголбанк, арилжааны банкинд худалдсан биет болон биет бус алтны нөөц ашигласны төлбөр борлуулалтын үнэлгээний 2,5 хувьтай тэнцүү” гэх заалт хүчингүй болсны улмаас Монголбанкинд худалдах алтны хэмжээ буурч, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд сөргөөр нөлөөлж болзошгүй болон хуулийн заалтын үйлчлэх хугацааг үргэлжлүүлэн мөрдөх саналтай байгаа талаар Монголбанкнаас 2018 оны А-1/940 дугаартай албан бичгээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яаманд мэдэгдсэн.

Түүнчлэн Монголын жонш олборлогч, үйлдвэрлэгч, экспортлогчдын холбооноос Ашигт малтмалын тухай хуулиар зөвхөн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг улсын төсөвт төлөхөөр зохицуулагдаж байгаагаас үүдэн бичил уурхайгаар ашигт малтмал олборлож буй нөхөрлөл, тэдгээрээс ашигт малтмал худалдан авч экспортлогчид, худалдсан этгээд болон ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийг нөөц ашигласны төлбөрийг төлөхгүй, холбогдох байгууллагуудад тайлан мэдээ өгөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж байгаа талаар дурдсан албан бичиг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яаманд тус тус ирүүлсэн.

Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 5-ны өдөр Төрийн ордонд хийсэн “Алт”, 2018 оны 06 дугаар сарын 07-ны өдөр хийсэн “Жонш” зөвлөлдөх уулзалт, 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Блю ский, Тауэр-т зохион байгуулагдсан “Алтны форум”-ын үеэр Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа талаар салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, эрдэмтэн судлаачид дурьдаж байсан болно.

Иймд тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй бичил уурхайгаар ашигт малтмал олборлож буй хоршоо, нөхөрлөл, тэдгээрээс ашигт малтмал худалдан авч экспортолсон, худалдсан этгээд болон ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх, тайлагнах, бүртгэлжүүлэх боломжийг

бүрдүүлэхийн зэрэгцээ Монголбанкинд тушааж буй алтны хэмжээг бууруулахгүй, улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх улмаар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төсөвт бүрэн төвлөрүүлэх, татварын суурийг өргөжүүлэх зорилгоор Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь 3 зүйлтэй байхаар тусгагдсан ба 1 дүгээр зүйлд тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй бичил уурхайгаар ашигт малтмал олборлож буй хоршоо, нөхөрлөл, тэдгээрээс ашигт малтмал худалдан авч экспортолсон, худалдсан этгээд болон ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх, тайлагнах, бүртгэлжүүлэх заалтуудыг тусгасан болно.

2 дугаар зүйлд аливаа этгээдийн тушаасан алтны төлбөрөөс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг суутган тооцох, түүнийг төсөвт төлөх, тайлагнах үүргийг Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд хүлээлгэх заалтыг нэмж тусгасан болно.

3 дугаар зүйлд хуулийн төсөлд шинэ заалт нэмж байгаатай холбоотойгоор зүйл, заалтын дугаарыг өөрчлөхөөр тусгасан. Хуулийн төсөлтэй хамт Монголбанкны худалдан авсан алтанд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг өөрөөр тогтоосон хуулийн заалтыг дагаж мөрдөх журмын хугацааг сунгахаар холбогдох өөрчлөлтийг оруулсан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй бичил уурхайгаар ашигт малтмал олборлож буй хоршоо, нөхөрлөл, тэдгээрээс ашигт малтмал худалдан авч экспортолсон, худалдсан этгээд болон ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх, тайлагнах, бүртгэлжүүлэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ Монголбанкинд тушааж буй алтны хэмжээг бууруулахгүй, улсын валютын нөөцийг нэмэгдүүлж, төгрөгийн ханшийг тогтворжуулах, улмаар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төсөвт бүрэн төвлөрүүлэх боломжийг бүрдүүлэх болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР